

12

**ИМАУ-ЫН ХАА-Н ЯАМНЫ КОЛЛЕГИ, УЛААНБААТАР  
ХОТЫН АДЛ-ЫН ГҮЙЛЭТГЭХ ЗАХИРГААНЫ ХАМТАРСАН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

1982 оны I-р сарын  
13-ны өдөр.

дугаар <sup>1/</sup>4/Ф

Улаанбаатар  
хот.

**НОГООНЫ КОМБИНАТАД БАРИЛГЫН АНГИ  
БАЙГУУЛАХ ТУХАЙ**

ИМАУ-ын Сайд Шары Зөвлөлийн товчооны хурлын 1982 оны 58-р протоколыг хэрэгжүүлэх үндсэн дээр ИМАУ-ын ХАА-н яамны коллеги, Улаанбаатар хотын АДЛ-ын Гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

IV-5

1. Ногооны комбинатад одоо ажиллаж байгаа барилгын бригадыг 1983 оноос эхлэн аж ахуйн тосцоотой барилгын анги болгон өргөтгөж ногооны зoorь, агуулагуудын их урсгал засвар, ногоочдын орон сууцыг барих үүрэгтэйгээр байгуулж, гүйцэтгэх ажлын программыг/төлөвлөгөөг/ боловсруулан батлаж өгөхийг Хотын төлөвлөгөөний комисс /н. Дугаржав/-т даалгасугай.

X-3      XIII-14

2. Мэргэжилтэй ажилчид, ажиллах хүчнээр хангахын тулд барилгын ТАС-ийн жил бүрийн төгсөлтөөс 15-20 ажилчин авч ажиллуулах асуудлыг УТн-д тавья шийдвэрлүүлэх, хотод оршин суугчдаас хөдөлмөр зохицуулах замаар дутагдах ажилчдыг шилжүүлэн өгч байхыг ХААУ газар /н. Батсүмбэр/, Хөдөлмөр нийгэм хангамжийн хэлтэс /н. Ланшан/-д даалгасугай.

II-6

3. Барилгын технологийн тээвэр, машин механизмын хангамжийг сайжруулахын тулд барилга ангийн нормативт машин техникийг 1983 онд хөрөнгө оруулалтаар хуваарилах буюу ХАА-н байгууллагуудаас шилжүүлэн өгөхийг ХАА-н яамны орлогч сайд /н. Адамгарав/-т даалгасугай.

X-3      XIII-14

4. Барилгын инженер техникийн голон бусад удирдах ажилтан мэргэжилтэн ажилчдыг 1983 оны сургууль төгсөгчдөөс ба харьяа газруудаас гаргаж Ногооны комбинатад шилжүүлэхийг ХАА-н яамны боловсон хүчний газар /н. Дагвадорж/-д даалгасугай.

5. Ногооны комбинатын барилга ангийн о он тоог боловруулан хянаж Хөдөлмөр нийгэм хангамжийн улсын хороонд оруулж шийдвэрлүүлэхийг санхүүгийн хэлтэс /н.Эрдэмбат/ ХААУ газар /н. Латсүмбэр/-д даалгасугай.

6. Зоориудын барилгын их засварын болон тоног төхөөрөмжийн шинэчлэлтийн зураг төслийг селен болгох шаардагдах тоног барилгын материалыг жил бүрийн улсын төлөвлөгөөнд тусгаж байхыг МАА-н яамны орлогч сайд /н. Цадамгарав/-д даалгасугай.



*[Handwritten signature]*  
С.СОЛНОМОРМ



УЛААН ААТАР ХОТЫН АДХ-ЫН  
БҮН ЭНГЭЭ ЗАХИРГААНЫ  
ДАРГА  
*[Handwritten signature]*  
С.МОНЖАНГАЛ